



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 16 өдөр

Дугаар А/791

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4 дүгээр хуралдааны 4/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цахим Ховд дэд хөтөлбөрийн хүрээнд цахим үйл ажиллагааг хэрэгжүүлэх аймгийн Засаг даргын Тамгын газрын тоног төхөөрөмжийг шинэчлэх зардлыг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 25 150 000 төгрөг /Хорин таван сая нэг зуун тавин мянган/-ийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтын 4.13 дахь Цахим Ховд хөтөлбөр арга хэмжээний зардлаас, 7 200 000 төгрөг /Арван таван сая нэг зуун наян мянган/-ийг 4.15 дахь Хариуцлагатай тунгалаг төр хөтөлбөр, арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг Даргын орлогч дарга /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны  
12 дугаар сарын 16-ны өдрийн  
А/791 дүгээр захирамжийн хавсралт



ЦАХИМ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ТОНОГ  
ТӨХӨӨРӨМЖ ШИНЭЧЛЭХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/ д	Тоног төхөөрөмжийн нэр төрөл	ХНэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Дүн /мян.төг/	Ашиглагч
1.	Процессор (i5 10400, DDR4 8GB/128 SSD).	ш	10	2 500 000	25 000.0	ТЗУХ-5ш, ХШУДАХ- 2ш, ХЭЗХ-2ш, НБХ-1ш,
2.	Зөөврийн компьютер (i5 10350, DDR4 4GB/1TB 15.6 inch).	ш	2	2 800 000	5 600.0	ТЗУХ-1ш, ХШУДАХ- 1ш.
3.	Принтер (НРлазер 3 үйлдэлтэй)	ш	2	875 000	1 750.0	ТЗУХ
ДҮН					32 350.0	

-oOo-